

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТООЛООР
ТЕРРОРИСТ ГЭЖ ЗАРЛАГДСАН БАЙГУУЛЛАГА, ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТЫГ ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ, ТЭДГЭЭРИЙН
ГҮЙЛГЭЭГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь терроризм болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхтэй холбогдуулж Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэсний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын конвенц, тогтоол (цаашид “тогтоол” гэх)-оор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалт (цаашид “жагсаалт” гэх)-ыг банкны байгууллагад мэдэгдэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлж холбогдох эрх бүхий төрийн байгууллага (цаашид “эрх бүхий төрийн байгууллага” гэх)-д шалгуулахаар мэдэгдэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон холбогдох бусад хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.

ХОЁР. ЖАГСААЛТЫГ ГАРГАХ, БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ

2.1. Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба (цаашид “Монголбанкны СМА” гэх) тогтоол болон жагсаалт, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг НҮБ-ын албан ёсны мэдээллийн эх сурвалжаас тогтмол татан авч, өөрийн мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулна.

2.2. Монголбанкны СМА жагсаалтыг Монгол хэлэнд хөрвүүлж бичгээр эсвэл цахим шуудангаар банкуудад илгээх ажлыг зохион байгуулна.

2.3. Монголбанкны СМА нь жагсаалтыг өөрийн веб хуудсаар дамжуулан олон нийтэд зарлаж болно.

ГУРАВ. БАНКНААС АВАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Банк Монголбанкны СМА-наас жагсаалтыг хүлээн авснаас хойш дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Өөрийн данс эзэмшигч, харилцагчдын дунд уг жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээд байгаа эсэхийг түргэн шуурхай, үнэн зөвөөр тогтоох;

3.1.2. Жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээд санхүүгийн үйлчилгээ хүлээн авагч, шилжүүлэгч эсхүл зуучлагч тал болж байгаа эсэхийг тогтоох;

3.1.3. Данс эзэмшигч, харилцагч, шилжүүлэгч, хүлээн авагч, зуучлагчдын дунд жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээд байгаа эсэхийг тогтоох талаар холбогдох ажилтнуудыг сургах;

3.1.4. Хувь хүн, хуулийн этгээдийн нэр жагсаалтад байгаа нэртэй тохирсон тохиолдолд гүйлгээг шууд түдгэлзүүлж, тухайн гүйлгээ, данс эзэмшигч болон холбогдох гүйлгээнд оролцогч талуудын тухай бүх мэдээллийг 24 цагийн дотор Монголбанкны СМА-нд мэдэгдэх.

3.2. Банк нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгч, хүлээн авагч, шилжүүлэгч болон зуучлагчийн мэдээллийг уг жагсаалттай тулган шалгадаг тогтолцоог бий болгоно.

3.3. Монголбанкны СМА эсхүл эрх бүхий төрийн байгууллагаас банкны түдгэлзүүлсэн гүйлгээ, данстай холбогдуулж тодорхой арга хэмжээ аваагүй, албан ёсны заавар, шийдвэр өгөөгүй бол 72 цагаас илүү хугацаагаар тухайн данс, гүйлгээг түдгэлзүүлэхгүй.

3.4. Банк гүйлгээг түдгэлзүүлэх гэж байгаа талаар тухайн хариуцагч, оролцогчид урьдчилан мэдэгдэхгүй бөгөөд тэдэнд аливаа хэлбэрээр мэдээлэхийг хориглоно.

ДӨРӨВ. МОНГОЛБАНКНЫ СМА-НААС АВАХ АРГА ХЭМЖЭЭ

4.1. Монголбанкны СМА нь жагсаалтад байгаа нэртэй тохирсон хувь хүн, хуулийн этгээдийн тухай мэдээллийг банкнаас хүлээн авмагц дараахь арга хэмжээг авна. Үүнд:

4.1.1. Албан ёсны жагсаалттай дахин тулган шалгаж тухайн хувь хүн, хуулийн этгээдийн нэр нь үнэн зөв тохирч байгаа эсэхийг нягтлан шалгах;

4.1.2. Дотоод, гадаадын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээллийг цуглуулж тухайн хувь хүн, хуулийн этгээд жагсаалтад байгаа байгууллага, этгээд мөн эсэхийг дахин лавлаж тодруулах;

4.1.3. Хувь хүн, хуулийн этгээдийн нэр террорист, эсхүл террористыг санхүүжүүлэгч хувь хүний жагсаалтад байгаа нэртэй тохирч байвал Монголбанкны СМА-ны дарга “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 11.1 дүгээр зүйлийн дагуу тухайн гүйлгээг ажлын 3 өдөр түдгэлзүүлэх шийдвэрийг банкинд нэн даруй албан бичгээр хүргүүлнэ. Ингэхдээ гүйлгээ түдгэлзүүлсэн хугацааг банк түдгэлзүүлж эхэлсэн хугацаагаар тооцно;

4.1.4. Монголбанкны СМА-ны дарга тухайн хувь хүн, хуулийн этгээдийн тухай мэдээллийг гүйлгээ түдгэлзүүлэх шийдвэрийн хуулбарын хамт

холбогдох эрх бүхий төрийн байгууллагад албан бичгээр мэдэгдэж арга хэмжээ авахуулна;

4.1.5. СМА жагсаалтад нэр нь орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр давхардсан, буруу тохирсон, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж энэ тухай банкинд нэн даруй албан бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Нэр давхардсан буюу жагсаалтад орсон нэртэй адилхан нэртэй иргэн, хуулийн этгээдийн гүйлгээг түдгэлзүүлсэн тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 12.2 болон 12.3 дугаар зүйлийг баримтална.

5.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол захиргааны шийтгэл ногдуулна.

_____оОо_____